ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn

2023.03.01 № 1/145

танай ______ -ны № ______ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хавсралт 42 хуудастай.

Хувийг: Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.БАТТУЛГА

14?330184

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022.12.08 Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу 2022 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны ”Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 47 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 3 зорилгын хүрээнд 10 зорилт 47 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж 36 арга хэмжээ “үр дүнтэй” буюу 100 хувь, 1 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 99 хүртэл хувь, 7 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” 31 – 69 хүртэл хувь, 3 арга хэмжээ “үр дүнгүй” 0- 30 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж зорилтын дундаж 90 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

| | | | |
|---|---|---|---|
| | 2.2.4 | Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд үндэсний хэмжээнд спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох, | 100% |
| | 2.2.5 | Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдэд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин хамтран ажиллах, | 100% |
| | 2.2.6 | Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд шинжлэх ухааны дэвшилтэд арга зүй нэвтрүүлж, судалгаа шинжилгээ хийж, өсвөрийн шигшээ багт хүрч ажиллах дэд бүтцийг сайжруулах, | 100% |
| | 2.2.7 | Спорт холбоодын урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулах, | 0% |
| | 2.2.8 | Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, | 100% |
| | 2.2.9 | Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, | 100% |
| | 2.2.10 | Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр нэмэгдүүлж, орон нутагт хамрах хүрээг нэмэх, | 100% |
| | 2.2.11 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах, | 100% |
| | 2.2.12 | Ахмад настны иргэдийг биеийн тамир спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах, | 100% |
| Стратегийн зорилго 3. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах | | | |
| Зорилт-3.1. Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ. | | | 83.3% |
| 5. | 3.1.1 | Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, дагалдах хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцүүлэх, | 100% |
| | 3.1.2 | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу боловсруулагдах 7 зорилтод хөтөлбөрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, | 100% |
| | 3.1.3 | Допингийн эсрэг үндэсний дүрмийн төсөл боловсруулах, | 100% |
| | 3.1.4 | Улсын хэмжээний тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулах, | 100% |
| | 3.1.5 | Биеийн тамир, спортын салбарын статистикийн мэдээний дүнг нэгтгэх, статистик мэдээллийг нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох | 100% |
| | 3.1.6 | Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн (сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах) хөтөлбөр батлах, | 0% |
| **Зорилт 3.2.** Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангана. | | | 100% |
| 6. | 3.2.1 | Засгийн газрын бодлого төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаж төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлнэ. | 100% |
| | 3.2.2 | Биеийн тамир, спортын салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, явц, үр дүнг мэдээлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана. | 100% |
| **Зорилт 3.3**. Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага, сахилга батыг сайжруулна. | | | % |
| 8. | 3.3.1 | Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" шинэчлэн боловсруулж, батлуулах, | 100% |
| **Зорилт 3.4.** Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааг агентлагийн болон салбарын хэмжээнд хангуулна. | | | 100% |
| 9. | 3.4.1 | Жендерийн салбар зөвлөл, хороо байгуулж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам, жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, | 100% |
| **Зорилт 3.5.** Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | | | 100% |

Гурав. Дүгнэлт

**Зорилт-1.1**-ийн хүрээнд туссан арга хэмжээ-1.1.3. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлэхэд E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн сангаас тамирчдын лавлагааны хөгжүүлэлтийн ажил удаашралтай байна.

**Зорилт-2.1**-ийн хүрээнд туссан арга хэмжээ 2.1.2. Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох ажил бодит үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй.

**Зорилт-2.2**-ийн хүрээнд туссан арга хэмжээ-2.2.2. Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг оновчтой зөв тайлагнах.

Арга хэмжээ-2.2.8. Спортын холбоодын урт хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулах ажил хангалтгүй байна.

**Зорилт 3.1**-ийн хүрээнд туссан арга хэмжээ 3.1.6. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн (сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах) хөтөлбөр батлах ажил салбарын хэмжээнд хүний нөөцийн ажил 2021, 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаад хэрэгжүүлж ажиллаагүй.

**Зорилт 3.3**-ийн хүрээнд туссан арга хэмжээ 3.3.1. Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" шинэчлэн боловсруулж, батлуулах ажил, тодорхойгүй шалтгаанаар батлагдахгүй удаашрах зөрчил, дутагдлыг арилгах ажлын уялдааг сайжруулж ажиллах.

Зорилт 3.10-ийн хүрээнд туссан арга хэмжээ 3.10.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит зорилтод түвшиндээ хүрээгүй байгаа нь тус тус дүгнэгдэж байна.

Дөрөв. Зөвлөмж

Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлэхэд E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн сангаас тамирчдын лавлагааны хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэхийг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Гадаад харилцаа, мэдээлэл технологийн хэлтэс.

Иргэд эрүүл, аюулгүй орчинд өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөл, спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөр боловсруулан стандарт, сургалтын хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж ажиллахыг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс.

Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох ажил бодит үр дүн гаргаж эрчимжүүлж ажиллахыг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс.

Спортын холбоодын урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулах ажлыг анхаарч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар.

Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн (сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах) хөтөлбөр батлах ажил 2 жил байгууллагын төлөвлөгөөнд тусгасан боловч хангалтгүй ажил хийгдэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг дурдаж тайлагнахыг Бодлого, төлөвлөлтийн газарт.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 02 сарын 09 өдөр Дугаар 01. Улаанбаатар хот

## ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Засгийн газрын 2020 оны "Журам батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай нийтлэг журам"-ын дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, хурлын шийдвэрийн хамт харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан дүгнэлт, санал зөвлөмжийг үндэслэн холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг нэгжийн дарга нарт үүрэг болгов.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.БАТТУЛГА

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022.12.07

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох. | | | | | | | |
| | **Зорилт-1.1** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. | 510 сая төгрөг | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо бүрдэх. | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо бүрдэх бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх арга хэмжээний суурь нөхцөл бүрдсэн. | 100% | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд спортын 63 холбоодтой ажил гүйцэтгүүлэх 67 гэрээгээр 1,2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, 704 түр ажлын байраар хангасан. Нийтдээ төрийн бус 97 байгууллагаар үйл ажиллагааг гүйцэтгүүлэн дэмжлэг үзүүлж, түр болон байнгын 949 ажлын байр бий болгон ажилласан. 21 аймгийн хэмжээнд нийт 123 арга зүйч ажиллаж, салбарын мэдээллийн сангийн цахим хөгжүүлэлтийн ажил 60% явагдаж байна. | 80% |
| 1. | **Арга хэмжээ-1.1.1** Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт | 149.619.100 | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний | 53 хувь | 56 хувь | Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандарт шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд БНСУ-н "Сорил-100" хөтөлбөр, Европын холбооны Европфит, Эрүүл мэндийн фитнессийн "Alpha-Fit", Казакстан болон Япон улсын сорилын программыг судалж Бие бялдрын түвшин тогтоох сорилын цахим сангийн өгөгдлийн ажлын даалгаврыг боловсруулж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Хүн амын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх | | тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ хувиар тооцно. | | | бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 9, 10 сард зохион байгуулсан. Улсын хэмжээнд 3-64 насны 347237 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдлаа. Үүнээс 166042 нь эмэгтэйчүүд 47.8%, 181195 эрэгтэйчүүд 52.2% тус тус эзэлж байна. Хамрагдсан нийт иргэдээс 272726 нь буюу 78.5% нь А,В,С хангалттай үнэлгээ авсан байна. Энэ нь нийт хүн амын 10.1% эзэлж байна. Эртэч нийгэм, эртэч иргэн, гэр бүлийг би болгох зорилгоор "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяныг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 06 дугаар сарын 1-ны хооронд өдөр бүр 06.30-07.30 цагт бүх насны иргэд дасгал хөдөлгөөнөөр цахимаар хичээллэх орчныг бүрдүүлсэн. Нийт ажлын 74 хоног 4320 минутын дасгал хөдөлгөөнийг спортын төв ордны "А" заалнаас шууд дамжуулж 21 аймаг, 9 дүүргийн 1650 гаруй цэгт иргэдэд цахимаар дасгал хөдөлгөөнийг заах улсын хэмжээнд давхардсан тоогоор 1,605,341 иргэн өглөөний дасгалд хамрагдсан байна.<br>Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн Хөдөлгөөн", "Дөл-2022" цэрэг-спортын цогцолбор тэмцээн, "Оюутны алтан намар" "Эрүүл мэндийнхээ төлөө – Алхангаа ярилцъя", "Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил", Өртөөт марафон, "Гимнастрада", Иогийн өдөр, "Авто машингүй өдөр", Тамирчдын баяр, "4 аймаг 400 км", Хүчний болон биеийн тамир, спортын байгууллагуудын нөхөрсөг арга хэмжээ, Шри Чинмойны санаачилсан ГАЛТ БАМБАР-ыг буухиачлах "Эвийн өргөө-Энхийн гүйлт 2022" биеийн тамирын арга хэмжээнүүдийг улсын хэмжээнд зохион байгуулж давхардсан тоогоор 505 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын 90261 хүн хамрагдан оролцлоо. Дээрх арга хэмжээний зардалд 149 619 100 сая төгрөгийг зарцуулан идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлсэн байна. | |
| 2. | **Арга хэмжээ-1.1.2.** Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх. | | Сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 110 болгосон байна. | 60 биеийн тамирын арга зүйч суманд ажиллаж байна. | Сумын биеийн тамирын арга зүйчийг 50-аар нэмэгдүүлнэ. | Биеийн тамирын арга зүйчийн судалгаа ирүүлэх тухай 2022 оны 1/869 дугаар албан бичгийг, хүснэгтийн хамт 21 аймгийн Биеийн тамир, спортын байгууллагын албаны цахим шуудангаар хүргүүлж судалгааг нэгтгэлээ. Судалгааг 10 дугаар сарын 12-ноос 25-ны хооронд зохион байгуулж 21 аймгийн хэмжээнд нийт 123 арга зүйч ажиллаж байна. Бүсээр авч үзвэл Баруун бүс - 26, Хангайн бүс - 50, Төвийн бүс - 16, Зүүн бүс – 8 арга зүйч ажиллаж байна. Арга зүйчдийн дунд сорил авах аргачлалын талаарх сургалтыг цахимаар зохион байгуулж 21 аймаг, 9 дүүргийн 123 арга зүйч хамрагдлаа. | 100% |
| 3. | **Арга хэмжээ-1.1.3.** Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлэх. | - | e-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн сангаас тамирчдын спортын цолны лавлагаа олгох ажлыг эхлүүлсэн байна. | Мэдээллийн нэгдсэн цахим сангийн программ хангамж ажиллаж эхэлсэн. | Спортын цол зэргийн систем ажиллаж, тус үйлчилгээг E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн сангаас тамирчдын лавлагаа олгодог болсон байна. | Нэгдсэн цахим сангийн хүрээнд техник хангамжийг бүрдүүлэн, төр ба төрийн бус байгууллагуудын ашиглагдаж байгаа мэдээллийн санг нэгтгэн спортын тэмцээн, наадмын систем, спортын цол, зэргийн систем, статистикийн дэд систем, сорилын систем, үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийг тус тус хийж нэгдсэн байдлаар зохион байгуулан мэдээллийн сангийн үйл ажиллагааны хөгжүүлэлт хийгдэж байна. Спортын цол, зэргийн олголтын үйлчилгээг 2022 онд төрийн мэдээллийн нэгдсэн emongolia порталд холбох ажлын хүрээнд цахим хөгжүүлэлтийн ажил 60% явагдаж байна. | 60% |
| 4. | **Арга хэмжээ-1.1.4.** Биеийн тамир, спортын чиглэлд | 825.450.313 | Улсын хэмжээнд нийт 86 ажлыг гэрээний дагуу | Гэрээний дагуу 77 ажлыг шилжүүлсэн. | Гэрээний дагуу 86 ажлыг | Ахмадын өдрийг угтаж зохион байгуулсан спортын 4 төрлийн арга хэмжээг Монголын мастеруудын биеийн тамир, спортын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох. | | шилжүүлсэн байна. | | шилжүүлсэн байна. | хороонд дэмжлэг үзүүлж хамтран зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан "Эрүүл Монгол хүн" өдөрлөгийг Баянхонгор аймагт Хөл бөмбөгийн "Грассруутс" сургалт, Хөл бөмбөгийн фестиваль, Сагсан бөмбөгийн 3x3 сонирхогчдын тэмцээн, Идэвхтэй хөдөлгөөний флэш моби, сумын арга зүйч нарийн сургалтыг "Эерэг амьдрал Эрүүл нийгэм" нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага, Хөл бөмбөгийн холбоо, Сагсан бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж явууллаа. Дээрх арга хэмжээнүүдэд нийт 1080 хүн хамрагдсан байна. Арга хэмжээнүүдэд 6 хүнийг түр ажлын байраар хангаж хамтарч ажилласан. МҮСН, МОСН, МБАТН-аар шигшээ тэмцээнийг зохион байгуулах спортын төрлийн 63 холбоодтой ажил гүйцэтгүүлэх 67 гэрээгээр 825.450.313 төгрөгийн дэмжлэг үзүүлж, 704 түр ажлын байраар хангасан. Нийтдээ төрийн бус 97 байгууллагаар үйл ажиллагааг гүйцэтгүүлэн дэмжлэг үзүүлж, /үндэсний шигшээ багуудтай гэрээ/ түр болон байнгын 949 ажлын байр бий болгон ажилласан. | |
| 5. | **Арга хэмжээ-1.1.5.** Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх судалгааг хийх | - | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын аргачлалыг сайжруулах судалгааг хийх | Судалгаа хийгдэн, сорил авах 2 хувилбарын төсөл боловсруулсан. | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын аргачлалыг сайжруулах судалгааг хийсэн байна | Биеийн жингийн индекс, сорилын үзүүлэлтэд суурилсан дасгал хөдөлгөөний жорын сан бүрдүүлэх стандарт боловсруулах ажлын хүрээнд БНСУ-н "Сорил-100" хөтөлбөр, Европын холбооны Европфит, Эрүүл мэндийн фитнесийн "Alpha-Fit", Казакстан болон Япон улсын сорилын программ хөтөлбөрүүдийг судалж бие бялдрын түвшин тогтоох сорилын цахим сангийн өгөгдлийн ажлын даалгавар, 2005 онд батлагдсан MNS:5538 "Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ" стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах саналыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан.<br>Мөн Оросын холбооны улсын "Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн" хөтөлбөртэй танилцах 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Улаан-Үүд хотод очиж хөтөлбөрийн үйл ажиллагаа, спортод өсвөрийн насны тамирчдыг сонгох, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, спортын барилга байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжил дээшлүүлэх 6 хоногийн сургалтад хамрагдсан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд<br>2005 онд батлагдсан MNS:5538 "Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ" стандартад заагдсан нас насны ангиллын норм, нормативыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 6. | **Арга хэмжээ-1.1.6.** Иргэд эрүүл, аюулгүй орчинд, өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөлийг спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөрөөр бүрдүүлэх, стандарт, хөтөлбөрийг боловсруулан батлуулах, | 30.0 сая төгрөг | Иргэдийн спортоор хичээллэхэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх стандарт 24, стандартыг хэрэгжүүлэх жишиг сургалтын хөтөлбөр 8 боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ. | 2020 онд 13 стандарт батлуулсан, 2 хөтөлбөрийн төсөл боловсруулсан | Стандарт-12, сургалтын хөтөлбөр-4 | Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/111 тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй техникийн хороо байгуулагдсан. Техникийн хороогоор бие бялдрын сорил, бадминтон, жудо, мөсний шагай, дартс, таеквондо, бүжиг спортын стандартын төслийг эхний шатны боловсруулалт хийгдэж анхны төслийг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.<br>Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд БНСУ-ын спортын жишиг хөтөлбөр болох "Спортын авьяас чадварыг хөгжүүлэх" төслийн хичээлийн хөтөлбөр, спортын арга зүйч, багшийн хичээлийн хөтөлбөрүүдийг судлан орчуулж шаардлагатай зүйлсийг тусган стандартын төслийг эцэслэн боловсруулсан. Нийт 6 спортын төрлийн стандартын төсөл | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | | боловсруулсан. Асуудал хариуцсан сул орон тоог нөхөгдөөгүй. | |
| 7. | **Арга хэмжээ-1.1.7.** Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх. | - | Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд 15 спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой өгөгдөл байршсан байна. | Мэдээллийн нэгдсэн цахим сангийн программ хангамжийн хүрээнд спортын холбоодын удирдлагын систем ажилласан байна. | Спортын 15 холбооны мэдээллийн системийг ажиллуулан спортын тэмцээн, наадмын дэлгэрэнгүй мэдээлэл байршуулна. | Нэгдсэн цахим сангийн хүрээнд техник хангамжийг бүрдүүлэн, төр ба төрийн бус байгууллагуудын ашиглагдаж байгаа мэдээллийн санг нэгтгэн спортын тэмцээн, наадмын систем, спортын цол, зэргийн систем, статистикийн дэд систем, сорилын систем, үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийг тус тус хийж нэгдсэн байдлаар зохион байгуулан мэдээллийн сангийн үйл ажиллагааны хөгжүүлэлт хийгдэж байна. Спортын 26 холбоодын мэдээллийн систем Спортын цол, зэргийн олголтын үйлчилгээг 2022 онд төрийн мэдээллийн нэгдсэн emongolia порталд холбох ажлын хүрээнд цахим хөгжүүлэлтийн ажил 60% явагдаж байна. | 60% |
| 8. | **Зорилт-1.2.** Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина | 16,670.0 сая төгрөг | Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбай, олон улсын жишигт нийцсэн спортын барилга, байгууламж. | Спортын зориулалтын стандарт талбай, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламж барих ажлын явц хийгдэж байна. | 100% | Улсын хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спорт цогцолбор 4, спорт заал 6, наадмын талбай 1, хөл бөмбөгийн талбай 1, мөсөн ордон 1, усан бассейн 1 нэмэгдэн ашиглалтад орж спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн. | 86.6% |
| 9. | **Арга хэмжээ-1.2.1.** Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулах. | 11,057.2 сая төгрөг | Усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад орсон байна | Барилга угсралтын ажил 80-90 хувьтай явагдаж байна | Баянзүрх, Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулах. | Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ барилга угсралтын ажлыг дуусгаж 2022 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах БА-009/2022 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан.<br>Налайх дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/ барилга угсралтын ажил нь газар шороо, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурь, төмөр бетон арагт бүтээц, хана, хамар ханын ажил, дээвэр, гадна, дотор засал, хаалга, цонх, халаалт, агаар сэлгэлт, гадна цахилгаан шугам сүлжээний ажлуудыг дуусгаж, 10 дугаар сарын байдлаар 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Дулаанд холбогдох ажил хүлээгдэж байгаа бөгөөд дотор заслыг ажлыг бүрэн дуусгаж 2022 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br><br>Баян-Зүрх дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ барилга угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 10 сарын байдлаар гадна тохижилтын ажлууд хийгдэж, бассейны тоног төхөөрөмж, агааржуулалт, галын систем, лифтний тоног төхөөрөмжийн захиалга хийгдэж, гэрээний хүрээнд суурилуулалтын ажлыг эхлүүлээд байна.<br><br>Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ барилга угсралтын ажил нь 2010 онд ЭМЯ-тай гэрээ байгуулсан боловч газрын маргаан үүссэний улмаас барилгын ажил эхлээгүй. 2018 оны 08 дугаар сард газрын асуудал шийдэгдэж БСШУСЯ-тай гэрээ сунгаж барилга угсралтын ажил эхлүүлсэн. Газар шерооны ажил, суурийн ажил, зоорины давхар, 1, 2 дугаар давхрын төмөр бетон хийцийн угсралтын ажил гүйцэтгэж дууссан. 2022 онд гадна шугам сүлжээний ажлын зураг шинээр боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Ус сувгийн техникийн нөхцөл олгогдоогүй улмаас барилга угсралтын ажлыг эхлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байна. | |
| 10. | **Арга хэмжээ-1.2.2.** Говь-сүмбэр, Дундговь, Сүхбаатар аймгуудад шинээр | 5,563.0 сая төгрөг | Говь-сүмбэр, Дундговь, Сүхбаатар аймгуудад шинээр | Нэг хэв маягийн зураг төсөвтэй, газрын асуудал шийдвэрлэгдсэн. | Говь-сүмбэр, Сүхбаатар Дундговь | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан Биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэх төсөл, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | спортын цогцолбор барих. | | спортын цогцолбор барина. | | аймгийн спортын цогцолбор барилгын ажлыг эхлүүлсэн байна. | арга хэмжээний жагсаалтын III.1.1.35 Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/, III .1.1.41 Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/ барилга угсралтын ажил шинээр эхлэхээр тус тус батлагдсан. 2022 оны 03 дугаар сард Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Их модун" ХХК-тай гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.<br>2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгч буюу "Жи жи ай" ХХК-тай гэрээ байгуулж, барилга угсралтын ажил эхэлсэн.<br>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Говь-сүмбэр аймагт шинээр хэрэгжүүлэх спорт цогцолборын барилга угсралтын ажил хасагдсан болно. | |
| 11. | **Арга хэмжээ-1.2.3.** Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв байгуулах. | - | Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв байгуулах барилга байгууламж ашиглалтад орсон байна. | Зураг төсөвтэй, газрын асуудал шийдвэрлэгдсэн | Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв аж ахуйн тооцоот төрийн өмчийн үйлдвэрийн газрыг байгуулна. | Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолоор Булган аймгийн Хангал сумын нутаг дахь "Спорт бэлтгэл, сургалтын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар, "Техник спортын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэн "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болгож өөрчлөн байгуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 268 дугаар тогтоолоор захирлыг томилон үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.** Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх | | | | | | |
| 13. | **Зорилт-2.1.** Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ | 70.0 сая төгрөг | Үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоо бүрдсэн байна. | Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлэх бодлогын баримт бичиг бүрдсэн. | 100% | “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн олон улсын спортын наадам бий болгох чиглэлээр салбар дундын уялдааг хангах зорилгоор Соёлын сайдын 2022 оны А/181 дүгээр тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Үндэсний уламжлалт спортыг дэлхий дахинд Монгол үндэстний үнэт зүйлс, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд олон улсын “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадмын удирдамжийг хамтран боловсруулсан бэлтгэл ажлыг хангаж, үндэсний спортын 17 холбоотой гэрээний дагуу 57.976.00 сая төгрөгийн үйл ажиллагааны дэмжлэг үзүүлсэн. | 76.6% |
| 14. | **Арга хэмжээ-2.1.1.** Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулах. | - | Иргэдийн наадам зохиогдсон байна. | | Иргэдийн наадам зохиогдсон байна. | Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу “Монголын Оюутаны спортын наадам”-ыг 2 жил тутамд зохион байгуулдаг. 2022 онд Монголын оюутны спортынV наадам эхний хагас жилд спортын 10 төрлөөр 29 их, дээд сургууль хамрагдсан. Улсын хэмжээний анхан шатын тэмцээнд 4500 тамирчид, шигшээ наадамд 1607 тамирчид хамрагдаж амжилтаараа медаль хүртсэн 459 тамирчин, дасгалжуулагч холбогдох журмын дагуу 176.400.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо.<br>Монголын үндэсний спортын наадмыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулагдаж 2022 онд өвлийн 2 төрлийг 2 сард, зуны 13 төрлийн тэмцээнийг 8 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан. шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 2648 тамирчид 53 багц, 561 медалийн төлөө өрсөлдсөн. Даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар 349, 5 сая | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн зардлыг Монголын үндэсний спортын хороотой 135 дугаар гэрээ байгуулан ажилласан. "Монголын үндэсний спортын VII наадам"-д медаль авсан 294 тамирчин, дасгалжуулагчдад Засгийн газрын тогтоолын дагуу 117,600,000 төгрөг мөнгөн шагнал олгохоор боллоо.<br>Монголын бүх ард түмний спортын наадмын 4 жил тутамд зохион байгуулахаар тогтосон. "Монголын бүх ард түмний спортын XV зуны наадам"-ыг 2022 онд хоёрдугаар хагас жилд зохион байгуулагдаж олимпын спортын 18 төрөл, оюуны спортын 2 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 6 төрөл, нийт 26 спортын төрөлд 4500 гаруй тамирчид оролцож, 1198 тамирчин, дасгалжуулагчид медаль авах бөгөөд Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу 1,161.5 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо.<br>2022 онд "Иргэдийн наадам"-ыг аймаг, нийслэл, дүүргийн 20 байгууллага 1-5 хүртэлх үе шаттайгаар спортын 2-10 хүртэлх төрлөөр зохион явуулахад 450 баг хорооны 548 багийн 107,225 иргэд хамрагдаж 299,723,900 төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. | |
| 15. | **Арга хэмжээ-2.1.2.** Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох. | - | Олон улсын үндэсний спортын наадам зохиогдсон байна. | Олон улсын үндэсний спортын наадмын үзэл баримтлалын бичиг баримт боловсруулагдаж байна | Олон улсын спортын наадмын спортын төрлүүдийг тогтоох, бэлтгэл ажил эхлүүлсэн байна. | "Нүүдэлчин Монгол" соёлын биет бус өвийн олон улсын спортын наадам бий болгох чиглэлээр салбар дундын уялдааг хангах зорилгоор Соёлын сайдын 2022 оны А/181 дүгээр тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Үндэсний уламжлалт спортыг дэлхий дахинд Монгол үндэстний үнэт зүйлс, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд олон улсын "Нүүдэлчин Монгол" соёлын биет бус өвийн их наадмын удирдамжийг хамтран боловсруулсан. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | **Арга хэмжээ-2.1.3.** Үндэсний уламжлалт спортын холбоодын хөгжлийг дэмжих, | 57.0 сая төгрөг | Үндэсний спортын холбоодыг үйл ажиллагааг дэмжих . | | Үйл ажиллагааны дэмжлэг үзүүлсэн байна. | Монголын үндэсний спортын VII наадмыг өвлийн 2 төрлийн тэмцээнийг 2022 оны 2 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Өвлийн төрлийн шигшээ тэмцээнд 426 тамирчид оролцсоноос Мөсний шагайн харваанд 126 харваач, мөсний сурын харваанд 300 харваач өрсөлдсөн. Даргын 2022 оны А/25 дугаар тушаалаар үндэсний спортын 17 холбоотой гэрээ байгуулан 57.976.00 сая төгрөгийн үйл ажиллагааны дэмжлэг үзүүллээ. | 100% |
| 17. | **Зорилт-2.2.** Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах | 14,238,3 тэр бум төгрөг | Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоо хөгжиж тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар. | "Рио-2016" Олимп, Паралимпийн наадамд спортын 9 төрөлд 43 эрх авч оролцсон. | | Монголын Үндэсний шигшээ багийг спортын 24 төрөлд дасгалжуулагч 48, эмч 4, залуучуудын шигшээ багт 15, насанд хүрэгчдийн шигшээ багт 167, нийт 234 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж бэлтгэл дасгалжуулалтыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөлтөд тусган бэлтгэл, дасгалжуулалтыг хангаж ажиллаж байна. | 90.7% |
| 18. | **Арга хэмжээ-2.2.1.** Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах | 1,997.5 сая төгрөг | Олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тоо | 1573 тамирчин, дасгалжуулагчдад 2,720,435.0 төгрөг | Журмын дагуу олгосон байна. | Засгийн газрын 2022 оны 83 дугаар тогтоолын дагуу олимп, паралимпийн наадам, олимпын наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, зай, жинд дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн 67 тамирчинд сар бүр 154,000,000.0 төгрөг, жилд 1,848,000,000.0 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож байна.<br>Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 2021 онд медаль хүртсэн 37 тамирчин, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээнээс медаль авсан тамирчдад сар бүр урамшуулал олгох | | | | | түүний дасгалжуулагчдад 423,900,000.0 төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгохоор Засгийн Газрын тогтоол гарсан. | |
| 19. | **Арга хэмжээ-2.2.2.** Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах. | - | 60 дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. | 53 дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан. | Мэргэшүүлэх сургалтад 60 дасгалжуулагч хамруулсан байна. | Агентлагийн даргын 2021 оны А/74 дүгээр тушаалаар "Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хичээлийн хөтөлбөр"-ийг баталсан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу "Төгсөлтийн дараах дасгалжуулагчийн мэргэшүүлэх сургалт"-ыг МУБИС-ын Биеийн тамирын сургуультай хамтран Аймаг, нийслэл, дүүргийн спортын газар, хороо, спортын холбоо, клубийн багш, дасгалжуулагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах сургалтад хамрагдах 53 хүний сургалтын зардалд 68,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Аймаг, дүүрэгт ажиллаж байгаа 30, спортын холбоодод ажиллаж байгаа 23, нийт 53 Биеийн тамирын дээд сургуулийг бакалавраар төгссөн төгсөгчид 20 кредитийн 7 хичээл, 8 долоо хоног үргэлжлэх сургалтад 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хамрагдсан.<br>Агентлагийн даргын 2021 оны А/167 дугаар тушаал "Биеийн тамирын арга зүйчийн мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр"ийг баталсан. Улсын хэмжээнд 100 арга зүйч ажиллаж байгаа ба "Эрүүл Монгол Хүн Хөдөлгөөн"-ий хүрээнд Баянхонгор аймгийн 19 сумын биеийн тамирын арга зүйчдэд хууль тогтоомж салбарын бодлого шийдвэрийг танилцууллаа.<br>Биеийн тамирын их дээд сургуульд сурч байгаа оюутнуудыг Оросын холбооны улсад мэргэжил дээшлүүлэх, давтан сургах талаар судалгааг авахад "Аварга" БТДСургуулиас 3, Мон-Алтиус БТДС-иас 7 нийт 10 оюутны судалгааг ирүүлсэн. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20. | **Арга хэмжээ-2.2.3.** Үндэсний шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах | 8 тэрбум | Спортын холбоодтой байгуулсан гэрээг дүгнэж, санхүүгийн зарцуулалтын дэлгэрэнгүй болон хураангуй судалгааг гаргаж баримтанд тулгуурлан дүгнэлт гарсан байна. | Зуны олимпын спортын 12, өвлийн олимпын спортын 3, зуны паралимпийн 6, өвлийн паралимпийн 1, нийт 22 спортын төрөлд Үндэсний шигшээ багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан. | Үндэсний шигшээ багийн зуны болон өвлийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хууль, журмын дагуу гэрээ байгуулан дасгалжуулагч, тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулна. | Агентлагийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн А/71, А/72, 05 дугаар сарын 24-ний А/97, 08 дугаар сарын 24-ний А/169 тоот тушаалуудаар Үндэсний шигшээ багийн цалин, орон тоог баталж спортын 25 төрөлд дасгалжуулагч 48, эмч 4, залуучуудын шигшээ багт 15 тамирчин, насанд хүрэгчдийн шигшээ багийн 172 тамирчин нийт 239 хүнийг 450.000.000 төгрөгийн цалин олгож гэрээ байгуулан ажлын байраар хангаж байна. Мөн гэрээний дагуу Үндэсний шигшээ багийн 25 төрлийн спортын холбоодын үйл ажиллагаанд 7.550.000.000 төгрөг зарцуулжээ. | 100% |
| 21. | **Арга хэмжээ-2.2.4.** Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд үндэсний хэмжээнд спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох | 1,300.0 тэрбум | Монголын бүх ард түмний спортын XV, Хүүхдийн спортын наадам, Оюутны спортын наадам зохион байгуулах | Спортын наадам зохион байгуулсан. | Монголын бүх ард түмний спортын XV, Оюутаны спортын V, Үндэсний спортын VII наадам, Улсын аварга шалгаруулах 60 тэмцээнийг удирдлага арга зүйгээр | Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу "Монголын Оюутаны спортын наадам"-ыг 2 жил тутамд зохион байгуулдаг. 2022 онд Монголын оюутны спортынV наадам эхний хагас жилд спортын 10 төрлөөр 29 их, дээд сургууль хамрагдсан. Улсын хэмжээний анхан шатын тэмцээнд 4500 тамирчид, шигшээ наадамд 1607 тамирчид хамрагдаж амжилтаараа медаль хүртсэн 459 тамирчин, дасгалжуулагч холбогдох журмын дагуу 176.400.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо.<br>Монголын үндэсний спортын наадмыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулагдаж 2022 онд өвлийн 2 төрлийг 2 сард, зуны 13 төрлийн тэмцээнийг 8 сард Улаанбаатар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ханган зохион явуулсан байна. | хотноо зохион байгуулсан. шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 2648 тамирчид 53 багц, 561 медалийн төлөө өрсөлдсөн. Даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар 349, 5 сая төгрөгийн зардлыг Монголын үндэсний спортын хороотой 135 дугаар гэрээ байгуулан ажилласан. "Монголын үндэсний спортын VII наадам"-д медаль авсан 294 тамирчин, дасгалжуулагчдад Засгийн газрын тогтоолын дагуу 117,600,000 төгрөг мөнгөн шагнал олгохоор боллоо.<br>Монголын бүх ард түмний спортын наадмын 4 жил тутамд зохион байгуулахаар тогтосон. "Монголын бүх ард түмний спортын XV зуны наадам"-ыг 2022 онд хоёрдугаар хагас жилд зохион байгуулагдаж олимпын спортын 18 төрөл, оюуны спортын 2 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 6 төрөл, нийт 26 спортын төрөлд 4500 гаруй тамирчид оролцож, 1198 тамирчин, дасгалжуулагчид медаль авах бөгөөд Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу 1,161.5 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо. | |
| 22. | **Арга хэмжээ-2.2.5.** Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдэд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин хамтран ажиллах | 700.0 сая төгрөг | Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдэд дэмжлэг үзүүлсэн байх | 2019 онд 11 олон улсын тэмцээн зохиогдсон. | Засгийн газрын тогтоолын дагуу спорт холбоодод дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байна. | Засгийн газрын 2022 оны 154 дугаартай "Жагсаалт батлах тухай" тогтоолоор Монгол Улсад 2022 онд зохион байгуулах олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтыг баталсан.<br>2022 онд зохион байгуулагдах Ази тивийн аварга шалгаруулах Чөлөөт бөх, Пауэрлифтингийн насанд хүрэгчдийн тэмцээн, Ази тивийн аварга шалгаруулах Таеквондогийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн тэмцээн, Жүдо бөхийн "Улаанбаатар их дуулга-2022" олон улсын тэмцээн, Жюү-Жицүгийн "Улаанбаатар про" олон улсын тэмцээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж агентлагийн даргын 2022 оны А/69 дүгээр тушаалаар 300 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Түүнчлэн, Засгийн газрын 2022 оны 227 дугаар тогтоолоор "Улаанбаатар их дуулга-2022" жүдо бөхийн олон улсын тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1,5 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлэж агентлагийн даргын 2022 оны А/110 дугаартай тушаалаар 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04 сард Буянт-Ухаа спортын ордонд зохион байгуулагдан 22 орны 250 гаруй тамирчин оролцсон байна.<br>Жүдо бөхийн "Улаанбаатар их дуулга-2022" олон улсын тэмцээнд 100 сая, Жюу-Жицүгийн "Улаанбаатар про" олон улсын тэмцээнд 30 сая төгрөгийн зардлыг тус тус олгосон. Ази тивийн аварга шалгаруулах Пауэрлифтингийн насанд хүрэгчдийн тэмцээнд 9 орны 103 төлөөлөгч оролцож тус тэмцээнд 30 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Таеквондогийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн тэмцээнийг зохион байгуулах хугацааг Азийн Таеквондогийн холбооноос зохион байгуулах байршил орныг өөрчилсөн. | |
| 23. | **Арга хэмжээ-2.2.6.** Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч | 50.0 сая төгрөг | Өсвөрийн шигшээ багийн тамирчдаас сорил авах, спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний хийх | Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдаас түүвэр судалгаа хийгдсэн. | Өсвөрийн шигшээ багийн тамирчдаас сорил авах, дасгалжуулагчдын сургалт-дасгалжуулалтын арга зүйд дүн шинжилгээ хийж, | 2022 оны байдлаар улсын хэмжээнд 9 дүүрэг 18 аймагт засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид байнгын бэлтгэл сургуулилт хийж ажиллаж байна. Улсын хэмжээнд 33 спортын төрөлд 5395 тамирчин үүнээс эрэгтэй 3196 эмэгтэй 2199 хүүхдүүд хичээллэж байна. Хичээллэгсдийг насны ангиллаар авч үзвэл 10 хүртэлх насны 1094, 10-14 хүртэлх насны 2216, 15-18 хүртэлх насны 2188 тамирчин ажиллаж байна. Өсвөрийн тамирчид энэ онд 1287 спортын тэмцээнд оролцож 1208 алт, 1036 мөнгө, 1419 хүрэл медаль хүртэж тамирчдад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
